

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Аудитын гэрчилгээ	2
Аудитын тайлан.....	4
2.1 Оршил	4
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3 Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	4
2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8 Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	6
2.10 Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12 Шилэн дансны мэдээлэл	8
2.13 Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
Менежментийн захидал	9
Аудит хийсэн санхүүгийн тайлан	11
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	11
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	16
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	17
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	19
Хавсралт	20
5.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20
5.2 Албан шаардлага.....	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ОББҮХ	Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Д.ГАНБОЛД ТАНАА

2020.02.21 № 06/588
танай _____-ны № _____-г

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа зөрчлийг эс тооцвол Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлийн дүн бидний тооцсон материаллаг байдлын түвшнээс давсан нь “Хязгаарлалттай” дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Хүрээлэн буй орчны судалгаа шинжилгээ хөтөлбөрийн зорилго, үйл ажиллагаанд хамааралгүй 33,912.2 мянган төгрөгийн зориулалт бус зардал гаргасан;
- Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо нь иргэдийн агаар, орчны бохирдлыг бууруулахад чиглэсэн ногоон төсөл, үйл ажиллагааг дэмжих зорилгоор олгосон санхүүжилтийг Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” тухай заалтууд, санхүүгийн тайлагналын Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Үүрэг хариуцлага


Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



2.1 Оршил

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганболд Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа, төсвийн зарцуулалт, бүртгэл тайлагналыг холбогдох стандарт, журам, зааврын дагуу хэрэгжүүлэх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 27-ноос 2020 оны 02 дугаар сарын 07-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор Э.Энхбаатар хариуцаж хэрэгжүүлэв.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03/523 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны үйл ажиллагааны эрхэм зорилгоо “эдийн засгийн өсөлт, нийгмийн хөгжлийн хандлагыг экосистемийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүй байхад чиглүүлж хамгаалах, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах, жам ёсоор нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэх, байгальд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар хүрээлэн байгаа орчны тогтвортой байдлыг хадгалж, ногоон хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хамтын ажиллагаа, хүчин чармайлтыг өрнүүлж хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад оршино” гэж тодорхойлсон байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилгод нийцсэн байгаль орчин, аялал жуулчлалын бодлогыг улс орны эдийн засаг, төсөв, санхүүгийн нөөц, олон улсын хамтын ажиллагааны бодлоготой уялдуулан тодорхойлж төлөвлөх, хэрэгжүүлэх, энэ чиглэлд Засгийн газрын манлайллыг хангах;
- Байгаль орчныг хамгаалах, аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээрх хувийн хэвшил, нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллага, төрийн бус байгууллага, иргэдийн үүсгэл санаачилга, хамтын ажиллагааг дэмжих, тэдгээрийн үйл ажиллагааг бодлогоор уялдуулан чиглүүлэх;
- Яам, салбарын албан хаагч, ажиллагсад байгаль орчныг хамгаалах, цэвэр технологийг дэмжих, аялал жуулчлалыг хөгжүүлэх шинжлэх ухааны ололт, олон улсын тэргүүний арга туршлагыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, мэргэжлийн ур чадвараа хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Байгаль орчны төлөв байдал, хувьсал өөрчлөлтийн чиг хандлагыг судлан шинжлэх, байгаль орчныг хамгаалах, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалахтай холбогдуулан үйлдвэрлэл, үйлчилгээ, хэрэглээнд шинжлэх ухааны ололт, цэвэр ногоон технологи нэвтрүүлэхэд урамшууллын болон зохицуулалтын хөшүүрэг ашиглах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хуулиудад нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Байгаль орчин, аялал жуулчлалын яамны мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой бүрэн нийцээгүй байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн тооцоолох групп ХХК-ийн Acolous программ хангамж ашигладаг байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Байгаль орчин, аялал жуулчлалын яамны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 12 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 29,369,104.2 мянган төгрөгөөс тооцон 293,691,0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1 хувиар буюу 589,927.7 мянган төгрөгөөр тооцсон нь нийт зардлын дүн өмнөх оноос 2 дахин нэмэгдсэнтэй холбоотой болно.

2.8 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 35,556,541.8 мянган төгрөгөөр буюу 274.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, урьдчилж гарсан зардлын данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
МӨНГӨН ХӨРӨНГӨ	1.0	1.0	0.00
АВЛАГА	529,857.2	2,023,601.6	1,493,744.5
УРЬДЧИЛГАА	7,970,211.6	28,876,906.8	20,906,695.2
БАРАА МАТЕРИАЛ	316,971.6	314,085.4	-2,886.2
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,142,861.8	4,225,901.9	83,040.1
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	12,959,903.2	48,516,445.0	35,556,541.8
НИЙТ ӨР ТӨЛБӨР	25,292.9	-	-25,292.9
Засгийн газрын хувь оролцоо	12,934,610.3	48,516,445.0	35,581,834.6
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	12,959,903.2	48,516,445.0	35,556,541.8

Авлага дансны үлдэгдэлд 1,712,080.7 мянган төгрөгийн татаас санхүүжилтийн авлага, 311,521.0 мянган төгрөгийн байгууллагаас авах авлага нь Цэвэр агаар сангаас шилжиж ирсэн авлага байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл өссөн нь Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2019 оны 19/01 тогтоолд тусгасан агаар, орчны бохирдлыг бууруулахад зориулж хэрэгжүүлж байгаа 32 ажлын урьдчилгаа санхүүжилтээс шалтгаалжээ.

2.9 ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрт зориулан 84,793,378.1 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 35,793,378.1 мянган төгрөгийг урсгал зардалд, 49,000,000.0 мянган төгрөгийг эргэж төлөгдөх цэвэр зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 84,793,378.1 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 79,351,423.4 мянган төгрөг буюу 93.6 хувьтай байгаа нь эргэж төлөгдөх цэвэр зээлийн зардалд 49,000,000.0 мянган төгрөг баталснаас 43,015,830.7 мянган төгрөгийн гүйцэтгэл гарснаас шалтгаалсан байна.

Нэмэлт төсөв: Гадаадын 3 төсөл хөтөлбөрөөс 2,056,450.0 мянган, Засгийн газрын нөөц сангаас 767,360.1 мянган, дээд шатны төсвийн захирагчаас 194,496.6 мянган, тендерийн материалын орлого 660.0 мянган, нийт 3,018,966.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бараа, ажил үйлчилгээний бусад зардалд 865,586.8 мянган, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 408,523.9 мянган, цалин, нийгмийн даатгалд 19,219.1 мянган, томилотт зочны зардалд 12,069.6 мянган, хангамж, бараа материалын зардалд 1,486.6 мянган, нийт 1,306,886.0 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 1,712,080.7 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2.10 АУДИТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 12 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 8 эрсдэл тодорхойлж нийт 20 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 14,911,116.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 13,108,215.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,766,281.9 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 36,619.5 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

1. Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2019 оны 19/01 тогтоолоор баталсан төсөл, арга хэмжээний хүрээнд худалдан авсан 13,075,948.2 мянган төгрөгийн хөрөнгө, тоног төхөөрөмжийг урьдчилж гарсан зардлаар бүртгэж, хөрөнгөөр бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1 дэх заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад 13,075,948.2 мянган төгрөгийн залруулга хийсэн.

2. Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдлийг 32,267.1 мянган төгрөгийн гүйцэтгэлээр бууруулан тайлагнаагүй.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад 32,267.1 мянган төгрөгийн залруулга хийсэн.

3. ОББҮХ нь иргэдийн агаар, орчны бохирдлыг бууруулахад чиглэсэн ногоон төсөл, үйл ажиллагааг дэмжих зорилгоор олгох зээлийн хүүгийн төлбөрийн жилийн 9 хувийн зардлыг санхүүжүүлэхээр арилжааны 3 банктай гэрээ байгуулж 3,000,000.0 мянган төгрөгийг төсвөөс олгосон байна. Гэрээний 2.1.3-т "... ба 2020 оны 02 дугаар сарын 29-ний өдрөөс өмнө Банк нь энэхүү гэрээнд заасан санхүүжилтийн 60 хувиас доошгүй хувийг гэрээнд заасан зориулалтаар ашиглаж, зээл олгосон байна" гэж заасан боловч 2020 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар 33,718.1 мянган төгрөг буюу 1.1 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

Аудитаар илэрсэн 36,619.5 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Санхүүгийн байдлын тайлангийн урьдчилгаа дансны үлдэгдэл 28,876,906.8 мянган төгрөгийн зарцуулалт, худалдан авсан хөрөнгийг данс бүртгэлд тусгасан эсэх, Орчны бохирдлыг

бууруулах үндэсний хороо нь иргэдийн агаар, орчны бохирдлыг бууруулахад чиглэсэн ногоон төсөл, үйл ажиллагааг дэмжих зорилгоор арилжааны 3 банканд олгосон санхүүжилтийн гүйцэтгэл, гэрээний биелэлтийг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12 Шилэн дансны мэдээлэл

Байгаль орчин, аялал жуулчлалын яам Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 123 мэдээллийг хугацаанд нь, 22 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13 Өмнөх аудитаар өгсөн АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 300,000.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосныг барагдуулсан, 17,200.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлэхээр холбогдох хариуцагчаас төлбөрийг гаргуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргасан нь шийдэгдээгүй байна.

Нийт 2 зөвлөмж өгснийг хэрэгжүүлсэн буюу зөвлөмжийн хэрэгжилт 93.5 хувьтай байна.

2.14 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Хязгаарлалттай” дүгнэлт

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлснийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаатай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын 2016 онд боловсруулсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт Засгийн газрын 2016 оны 91 дүгээр тогтоолоор баталсан яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлт, Сангийн сайдын 2015 оны 341, 2018 оны 207, 2019 оны 74 дүгээр тушаалууд, стандартын өөрчлөлтийг тусгаагүй байна.

3.1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, холбогдох тушаал шийдвэр, стандартын өөрчлөлтийг тусгаагүй байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын 2016 оны 91 дүгээр тогтоол, Сангийн сайдын тушаал, стандартын өөрчлөлтийг тусгаж, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлтийг тусгах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлээр танилцуулсан болно.

Зардлын данстай холбоотой асуудал

3.1.5 Илрүүлэлт:

Хүрээлэн буй орчны судалгаа, шинжилгээ хөтөлбөрийн зорилго, үйл ажиллагаанд хамааралгүй 33,912.2 мянган төгрөгийн зориулалт бус зардал гарсан байна.

3.1.6 Эрсдэл:

Төсвийг зориулалт бусаар зарцуулах, холбогдох хууль, журмын заалтыг мөрдөж ажиллаагүй байх.

3.1.7 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

3.1.8 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлээр танилцуулсан болно.

Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

3.1.9 Илрүүлэлт:

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, судалгаа шинжилгээ хийх зорилгоор Арабын Нэгдсэн Эмират улсаас буцалтгүй тусламжаар ирсэн 45 ширхэг Mitsubishi pick up L200 маркын автомашиныг данс бүртгэлд тусгалгүй Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/485 тушаалаар харьяа 39 байгууллагад 40 автомашиныг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн 2019 оны Х/877, Х/1076 дугаар албан бичгүүдээр Монголын эмэгтэйчүүдийн холбоо, Монгол цэргийн нэгдсэн холбоо, Гандантэгчэнлин хийд, Үндэсний батлан хамгаалах их сургууль зэрэг байгууллагуудад 5 автомашиныг хуваарилсан байна. Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хуваарилсан 2 автомашины тос тосолгоо, даатгал, шатахууны зардалд 2,707.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

3.1.10 Эрсдэл:

Хөрөнгө хариуцах эзэнгүй орхигдох, батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулах.

3.1.11 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” нягтлан бодох бүртгэлд заавал тусгах гэж заасныг хэрэгжүүлж ажиллах.

3.1.12 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлээр танилцуулсан болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	8,817,041,402.70	44,290,543,031.81
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,000.00	1,000.00
33	АВЛАГА	529,857,191.41	2,023,601,647.50
33300	Татаас, санхүүжилтийн авлага	216,996,579.17	1,712,080,654.17
33500	Бусад авлага	312,860,612.24	311,520,993.33
33510	Байгууллагаас авах авлага	312,860,612.24	311,520,993.33
34	УРЬДЧИЛГАА	7,970,211,603.00	28,876,906,790.12
34600	Урьдчилж гарсан зардал	7,960,346,583.00	28,873,932,790.12
34710	Урьдчилгаа тооцоо	9,865,020.00	2,974,000.00
34714	Томилолтын урьдчилгаа	9,865,020.00	2,974,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	316,971,608.29	314,085,394.19
35100	Түүхий эд материал	0	14,592,300.00
35110	Тусгай зориулалттай материал	0	14,592,300.00
35400	Хангамжийн материал	316,971,608.29	299,493,094.19
35410	Бичиг хэргийн материал	14,588,147.60	7,674,837.60
35420	Аж ахуйн материал	277,016,085.25	265,686,638.25
35430	Сэлбэг хэрэгсэл	11,838,600.00	13,643,600.00
35440	Түлш, шатах тослох материал	1,433,411.00	2,218,040.00
35470	Бусад хангамжийн материал	12,095,364.44	10,269,978.34
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	0	13,075,948,200.00
36800	Бусад эргэлтийн хөрөнгө	0	13,075,948,200.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,142,861,787.94	4,225,901,919.36
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,142,861,787.94	4,225,901,919.36
39200	Биет хөрөнгө	3,186,179,788.13	3,298,799,919.48
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,011,958,613.18	1,011,958,613.18
39202	Хуримтлагдсан элэгдэл	0	-26,630,489.88
39203	Авто-тээврийн хэрэгсэл	397,536,600.00	539,939,067.26
39204	Хуримтлагдсан элэгдэл	-131,443,941.62	-162,719,008.30
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,885,080,209.02	2,074,453,457.73
39206	Хуримтлагдсан элэгдэл	-1,629,570,823.41	-1,746,233,722.03
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	679,769,925.82	704,703,643.25
39208	Хуримтлагдсан элэгдэл	-585,762,951.38	-606,448,496.91
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1,174,000,000.00	1,174,000,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	607,335,441.00	607,335,441.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-222,723,284.48	-271,558,585.82
39300	Биет бус хөрөнгө	956,681,999.81	927,101,999.88
39301	Програм хангамж	22,748,250.00	22,748,250.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-22,508,250.08	-22,588,250.12
39303	Бусад биет бус хөрөнгө	1,169,453,400.00	1,169,453,400.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-213,011,400.11	-242,511,400.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	12,959,903,190.64	48,516,444,951.17
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	25,292,877.00	0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	25,292,877.00	0
41300	Өглөг	25,292,877.00	0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	12,934,610,313.64	48,516,444,951.17
51	Засгийн газрын хувь оролцоо	12,934,610,313.64	48,516,444,951.17
51100	Засгийн газрын оруулсан капитал	3,881,171,779.25	3,881,171,779.25
51200	Хуримтлагдсан үр дүн	8,285,308,727.31	43,867,143,364.84
51210	Өмнөх үеийн үр дүн	5,822,536,505.74	6,187,330,461.71
51220	Тайлант үеийн үр дүн	2,462,772,221.57	37,679,812,903.13
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	768,129,807.08	768,129,807.08
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	12,959,903,190.64	48,516,444,951.17

4.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	31,832,246,434.33	83,596,636,130.64
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	435,893,820.16	322,419,027.47
120	Нийтлэг татварын бус орлого	435,893,820.16	322,419,027.47
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	435,893,820.16	322,419,027.47
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	42,689,366.16	16,516,499.57
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	393,204,454.00	305,902,527.90
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	31,396,352,614.17	83,274,217,103.17
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	29,554,019,557.00	80,255,250,415.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	29,554,019,557.00	80,255,250,415.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,842,333,057.17	3,018,966,688.17
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,842,333,057.17	2,251,606,637.17
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	767,360,051.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	29,211,366,676.06	32,321,112,658.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	18,939,366,993.73	32,321,112,658.85
